



**ЭМ, ЭМНЭЛГИЙН ХЭРЭГСЛИЙН ХЯНАЛТ,
ЗОХИЦУУЛАЛТЫН ГАЗРЫН ДАРГЫН
ТУШААЛ**

2022 оны 03 сарын 25 өдөр

Дугаар А/52

Улаанбаатар хот

**Байгууллагын цахим хуудасны үйл
ажиллагааг зохицуулах журам батлах тухай**

Засгийн газрын агентлагийн эрх зүйн байдлын тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.1.1, 8 дугаар зүйлийн 8.3.1, 8.4, Захиргааны ерөнхий хуулийн 40 дүгээр зүйлийн 40.1, Мэдээллийн ил тод байдал ба мэдээлэл авах эрхийн тухай хуулийн 11,13,14 дүгээр зүйл, Засгийн газрын 2013 оны "Мэдээллийн ил тод байдлыг хангах нийтлэг журам батлах тухай" 411 дүгээр тогтоолыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1.Байгууллагын үйл ажиллагааг иргэд, олон нийтэд мэдээлэх "Байгууллагын цахим хуудасны үйл ажиллагааг зохицуулах журам"-ыг нэгдүгээр хавсралтаар, мэдээлэх хуудсыг хоёрдугаар хавсралтаар баталсугай.

2.Журмыг хэрэгжүүлж ажиллахыг нийт албан хаагчдад, журмын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг газар, хэлстийн дарга нарт даалгасугай.

3.Энэ тушаал гарсантай холбогдуулан журмыг мөрдүүлж ажиллахыг Захиргаа, удирдлагын газар (Л.Намхайноров)-т даалгасугай.

ДЭД ДАРГА, ДАРГЫН ҮҮРГИЙГ
ХАВСРАН ГҮЙЦЭТГЭГЧ



Д.УРАНЗАЯА

142022 01052